

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2017 ОНЫ ХОРИН ТАВДУГААР

Хуралдаан 2017 оны арван нэгдүгээр сарын 30-ны 14 цаг 10 минутад эхэлж, 17 цаг 25 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д 3 цаг 15 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах Комиссын удирдах албан тушаалд томилогдох сонгон шалгаруулалтын нэгдсэн дүн, тайланг танилцуулав	
2	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтанд дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай	Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 39 дүгээр зүйл, Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдааны шийдвэр, Сонгон шалгаруулах комиссын 2017 оны НСШ/34 дүгээр дүгнэлтийг тус тус үндэслэн: Гочоосүрэнгийн Байгалмааг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэж, уг албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга /З.Энхболд/-д санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.
3	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтанд дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай	Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг

		<p>сонгон шалгаруулах журам”-ын 14 дүгээр зүйлийн “а”, Сонгон шалгаруулах комиссын Д/58 дугаар дүгнэлт, Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <p>Даажингийн Энхбатыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Л.Баяртулга/-д санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p>
4	<p>Барилга, хот байгуулалтын яамны Нийтийн аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтанд дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14 дүгээр зүйлийн “б”, Сонгон шалгаруулах комиссын Д/59 дүгээр дүгнэлт, Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <p>Орсоогийн Лхагвацэдэнг Барилга, хот байгуулалтын яамны Нийтийн аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга /С.Магнайсүрэн/-д санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p>
5	<p>Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны Хадгаламж, зээлийн хоршооны газрын даргын албан тушаалд томилогдох удирдах</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн</p>

	ажилтанд дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай	жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-ын 14 дүгээр зүйлийн "а", Сонгон шалгаруулах комиссын Д/60 дугаар дүгнэлт, Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн: Цогтсайханы Алтантуулыг Санхүүгийн зохицуулах хорооны Хадгаламж, зээлийн хоршооны газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны дарга /Т.Жамбаажамц/-д санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.
6	Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны Захиргаа удирдлагын газрын орлогч даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтанд дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай	Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-ын 14 дүгээр зүйлийн "а", Сонгон шалгаруулах комиссын Д/61 дүгээр дүгнэлт, Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн: Дашдоржийн Гэрэлчулууныг Санхүүгийн зохицуулах хорооны Захиргаа удирдлагын газрын орлогч даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны дарга /Т.Жамбаажамц/-д санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.
7	Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны Дотоод хяналтын хэлтсийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтанд	Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан "Төрийн

	<p>дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p>	<p>жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-ын 14 дүгээр зүйлийн "а", Сонгон шалгаруулах комиссын Д/62 дугаар дүгнэлт, Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <p>Насанжаргалын Нямдавааг Санхүүгийн зохицуулах хорооны Дотоод хяналтын хэлтсийн даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны дарга /Т.Жамбаажамц/-д санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p>
8	<p>Төв, Дорнод, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад хийсэн хяналт, шалгалтын дүн танилцуулах</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйл, 35 дугаар зүйлийн 35.1.2, 35.1.6, 39 дүгээр зүйлийн 39.6 дахь хэсэг, Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 2.2.1. дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.3, 17.4, 17.5-д заасныг зөрчиж төрийн жинхэнэ албаны шалгалт өгөөгүй энэхүү тогтоолын нэгдүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 31 иргэнийг төрийн жинхэнэ албан тушаалд томилсон тушаалуудыг 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор хүчингүй болгохыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга, Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын албаны дарга, Нийслэлийн Засаг даргын</p>

	<p>хэрэгжүүлэгч агентлаг Авто замын хөгжлийн газрын дарга, Боловсролын газрын дарга, Газрын албаны дарга, Өмчийн харилцааны газрын дарга, Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга, Залуучуудын хөгжлийн газрын дарга, Нийгмийн халамжийн газрын дарга нарт тус тус даалгах</p> <p>2. Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх Салбар зөвлөлийн сонгон шалгаруулалт, дүгнэлтгүйгээр энэхүү тогтоолын хоёрдугаар хавсралтад дурдсан нэр бүхий 16 иргэнийг төрийн жинхэнэ албан тушаалд түр орон гүйцэтгэгчээр томилсон зөрчлийг арилгаж, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”, Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 99 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журам”-ын дагуу 2017 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн дотор томилгоо хийхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Газрын албаны дарга, Өмчийн харилцааны газрын дарга, Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга, Залуучуудын хөгжлийн газрын дарга, Нийгмийн халамжийн газрын дарга, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын газрын дарга нарт тус тус үүрэг болгох</p> <p>3. Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо нөхөх Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу нөхөх арга хэмжээ авах, тогтоолын 1, 2 дахь хэсгийг тогтоосон хугацаанд</p>
--	--

		<p>хэрэгжүүлээгүй албан тушаалтанд хууль тогтоомжид заасан зохих арга хэмжээ авах саналыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхийг Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх Салбар зөвлөлийн дарга М.Отгонбаярт даалгах</p> <p>4. Нийслэлийн нутгийн захиргааны бусад төрийн байгууллагуудад хяналт, шалгалт хийж илэрсэн зөрчлийг арилган, хяналт, шалгалтын нэгдсэн дүнг 2018 оны нэгдүгээр улиралд багтаан Төрийн албаны зөвлөлийн хуралдаанд танилцуулахыг Нийслэл дэх салбар зөвлөлийн дарга М.Отгонбаярт үүрэг болгох</p> <p>5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, энэхүү тогтоолд дурдсан зөрчлийг арилгаагүй албан тушаалтанд хууль тогтоомжид заасан арга хэмжээ Төрийн албаны зөвлөлийн хуралдаанд танилцуулахыг Зөвлөлийн Ажлын алба /Д.Баатарсайхан/-д даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 35.1.6, 39 дүгээр зүйлийн 39.6, Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн “хоёр”-ын 2.2.1 дэх хэсгийг үндэслэн Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанаар Дорнод аймгийн төрийн захиргааны зарим байгууллагад хийсэн хяналт, шалгалт, төрийн байгууллагын үйл ажиллагааны өнөөгийн байдал, ажил үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар иргэдийн сэтгэл ханамжийн судалгааны дүнг хэлэлцээд:</p> <p>1. Төрийн албаны тухай</p>
--	--	---

	<p>хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 2, 4, 10, 14.а, 14.б-д заасныг зөрчиж дүгнэлт гаргасан Төрийн албаны зөвлөлийн Дорнод аймаг дахь салбар зөвлөлийн “Дүгнэлт гаргах тухай” 2016 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн 22, 2016 оны 08 дугаар сарын 11-ны өдрийн 26, 2016 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 48 дугаар тогтоолыг 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор хууль тогтоомжид нийцүүлэн хүчингүй болгохыг тус аймаг дахь Салбар зөвлөлийн дарга П.Бат-Өлзийд даалгах</p> <p>2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, Нийгмийн бодлогын хэлтсийн дарга, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга, Боловсрол, соёл, урлагийн газрын дарга, Орон нутгийн өмчийн газрын даргын болон түр орлон гүйцэтгэгч ажиллаж байгаа төрийн захиргааны удирдах, гүйцэтгэх, төрийн үйлчилгээний удирдах албан тушаалын сул ажлын байранд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтыг 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор зохион байгуулж, хууль тогтоомжийн дагуу нөхөх арга хэмжээ авахыг холбогдох байгууллагын эрх бүхий албан тушаалтанд даалгах</p> <p>3. Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийн нэгжийн дарга нарыг сэлгэн ажиллуулсан шийдвэрүүдийг хууль, тогтоомжид нийцүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга П.Бат-Өлзийд зөвлөх</p> <p>4. Тус аймгийн нутгийн</p>
--	---

	<p>захиргааны бусад байгууллагуудад хяналт, шалгалтыг үргэлжлүүлэн хийж, илэрсэн зөрчлийг арилгуулан “Хууль тогтоомжийн хэрэгжилт, төрийн албан хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх талаар хийж буй ажил, үр дүн” сэдэвт сонсголыг Төрийн албаны зөвлөлийн 2018 оны 3 дугаар сарын хуралдаанд хэлэлцүүлэхийг Дорнод аймаг дахь салбар зөвлөлийн дарга П.Бат-Өлзийд даалгах</p> <p>5. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж дурдсан зөрчлийг арилгаагүй албан тушаалтанд хууль тогтоомжид заасан арга хэмжээ авах санал танилцуулахыг Төрийн албаны зөвлөлийн Ажлын алба /Д.Баатарсайхан/-д үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 35.1.3 Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн 4.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаан шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хуулийн хэлтсийн дарга, Боловсрол, соёл, урлагийн газрын дарга, Баянжаргал сумын Засаг даргын Тамгын газрын даргын ажлын байранд тус тус томилогдох ажилтны сонгон шалгаруулалтыг 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор зохион байгуулж, Төрийн албаны зөвлөлд тайлагнахыг Төв аймаг дахь Салбар зөвлөлийн дарга Ч.Сарангэрэлд үүрэг болгох</p> <p>2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба</p>
--	---

		<p>Д.Баатарсайханд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 35.1.3, Монгол Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн 4.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <ol style="list-style-type: none"> 1. Төрийн албаны удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг зохион байгуулах аргачлал”-ыг хавсралтаар батлах 2. Энэхүү аргачлалыг мөрдөж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дарга, аймаг, нийслэл дэх Боловсрол, соёлын газрын дарга нарт үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.
9	<p>Булган, Баянхонгор, Дундговь Дорноговь аймгийн нутгийн захиргааны байгууллагын төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо нөхөх мэргэшлийн шалгалтын дүн</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйл, Төрийн албаны зөвлөлийн Булган аймаг дахь Салбар зөвлөлийн 2017 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 113 албан тоот албан бичиг төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p>

		<p>1. Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 1 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 64 иргэнийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д, 2 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 46 иргэнийг “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д тус тус бүртгэх</p> <p>2. Энэхүү тогтоолын нэгд заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс гуравдугаар хавсралтад дурдсан хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 7 иргэн, “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс дөрөвдүгээр хавсралтад дурдсан хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 13 иргэнийг тус тусын өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар нэр дэвшүүлэх</p> <p>3. Тогтоолын хоёрт дурдсан нэр бүхий 20 иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулахыг Төрийн албаны зөвлөлийн Булган аймаг дахь Салбар зөвлөл /Б.Ууганбаяр/-д үүрэг болгох</p> <p>4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны Ажлын алба /Д.Баатарсайхан/-д даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p>
--	--	---

		<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйл, Төрийн албаны зөвлөлийн Баянхонгор аймаг дахь Салбар зөвлөлийн 2017 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 208 тоот албан бичиг болон төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <ol style="list-style-type: none">1. Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 1 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 13 иргэнийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д, 2 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 14 иргэнийг “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д тус тус бүртгэх2. Энэхүү тогтоолын нэгд заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс гуравдугаар хавсралтад дурдсан хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 5 иргэн, “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс дөрөвдүгээр хавсралтад дурдсан хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 7 иргэнийг тус тусын өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар нэр дэвшүүлэх3. Тогтоолын хоёрт
--	--	---

	<p>дурдсан нэр бүхий 12 иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулах, нээлттэй сонгон шалгаруулалтаар нөхөгдөөгүй ажлын байруудыг хуулийн хүрээнд нөхөх арга хэмжээ авах, сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй мэдээллэх, иргэдэд сургалт, зөвлөгөө өгч ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Баянхонгор аймаг дахь Салбар зөвлөл /Ц.Дашцэрэн/-д үүрэг болгох</p> <p>4. Тогтоолын биелэлтэд хяналт тавих, ажлын байрны сул орон тоог цахим хуудсаар олон нийтэд хүртээмжтэй нээлттэй мэдээлэх, сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг мэргэшил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Төрийн албаны Ажлын алба /Д.Баатарсайхан/-д даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйл, Төрийн албаны зөвлөлийн Дундговь аймаг дахь Салбар зөвлөлийн 2017 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 138 тоот албан бичиг болон төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд</p>
--	--

	<p>бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <p>1. Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 1 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 12 иргэнийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д, 2 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 7 иргэнийг “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д тус тус бүртгэх</p> <p>2. Энэхүү тогтоолын нэгд заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс гуравдугаар хавсралтад дурдсан хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 3 иргэн, “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс дөрөвдүгээр хавсралтад дурдсан хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 3 иргэнийг тус тусын өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар нэр дэвшүүлэх</p> <p>3. Тогтоолын хоёрт дурдсан нэр бүхий 6 иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулах, нээлттэй сонгон шалгаруулалтаар нөхөгдөөгүй ажлын байруудыг хуулийн хүрээнд нөхөх арга хэмжээ авах, сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг</p>
--	---

	<p>олон нийтэд нээлттэй мэдээллэх, иргэдэд сургалт, зөвлөгөө өгч ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Дундговь аймаг дахь Салбар зөвлөл /Ц.Эрдэнэсүрэн/-д үүрэг болгох</p> <p>4. Тогтоолын биелэлтэд хяналт тавих, ажлын байрны сул орон тоог цахим хуудсаар олон нийтэд хүртээмжтэй нээлттэй мэдээлэх, сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг мэргэшил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Төрийн албаны Ажлын алба /Д.Баатарсайхан/-д даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйл, Төрийн албаны зөвлөлийн Дорноговь аймаг дахь Салбар зөвлөлийн 2017 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 133 тоот албан бичиг болон төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <p>1. Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 1 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 58 иргэнийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д, 2 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 24 иргэнийг “Туслах түшмэлийн ангиллын төрийн</p>
--	--

	<p>жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д тус тус бүртгэх</p> <p>2. Энэхүү тогтоолын нэгд заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс гуравдугаар хавсралтад дурдсан хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 12 иргэн, “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс дөрөвдүгээр хавсралтад дурдсан хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 16 иргэнийг тус тусын өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар нэр дэвшүүлэх</p> <p>3. Тогтоолын хоёрт дурдсан нэр бүхий 28 иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулах, нээлттэй сонгон шалгаруулалтаар нөхөгдөөгүй ажлын байруудыг хуулийн хүрээнд нөхөх арга хэмжээ авах, сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй мэдээллэх, иргэдэд сургалт, зөвлөгөө өгч ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Дорноговь аймаг дахь Салбар зөвлөл /Б.Ганзориг /-д үүрэг болгох</p> <p>4. Тогтоолын биелэлтэд хяналт тавих, ажлын байрны сул орон тоог цахим хуудсаар олон нийтэд хүртээмжтэй нээлттэй мэдээлэх, сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг мэргэшил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Төрийн албаны Ажлын алба</p>
--	---

	<p>/Д.Баатарсайхан/-д даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйл, Өвөрхангай аймаг дахь Салбар зөвлөлийн 2017 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 113 тоот албан бичиг болон төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <ol style="list-style-type: none">1. Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 1 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 25 иргэнийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д, 2 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 29 иргэнийг “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д тус тус бүртгэх2. Энэхүү тогтоолын нэгд заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс гуравдугаар хавсралтад дурдсан хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 9 иргэн, “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс дөрөвдүгээр хавсралтад дурдсан хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 13 иргэнийг тус тусын өрсөлдсөн албан тушаалд нь
--	---

		<p>томилуулахаар нэр дэвшүүлэх</p> <p>3. Тогтоолын хоёрт дурдсан нэр бүхий 22 иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулах арга хэмжээ авахыг Төрийн албаны зөвлөлийн Өвөрхангай аймаг дахь Салбар зөвлөл /Ц.Ганболд/-д үүрэг болгох</p> <p>4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Ажлын албан /Д.Баатарсайхан/-д даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p>
--	--	---

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
АЖЛЫН АЛБА**